

Үзүүлэлтүүд:



<p><b>ДНБ 5.6%</b> 2017 оны II-р улирлын байдлаар</p>	<p>ГШХО 7-р сард <b>-123.8 сая ам.доллар</b></p>	<p>Төсвийн алдагдал <b>-577 тэрбум төгрөг</b></p>	<p>Инфляци <b>5%</b></p>	<p>Чанаргүй зээл <b>1171 тэрбум төгрөг</b></p>	<p>Валютын нөөц <b>1.5 тэрбум ам.доллар</b></p>
<p>ДНБ-ий 5.6 хувиар өсөхөд бүтээгдэхүүний цэвэр татвар 24 хувь, үйлчилгээний салбар 9 хувиар өссөн нь нөлөөлөв.</p>	<p>Цэвэр ГШХО 7-р сарын байдлаар -123.8 сая ам.доллар өмнөх оны мөн үеэс 135.5 сая ам.доллараар буурав.</p>	<p>Төсвийн орлого 4467 тэрбум төгрөг, зарлага 5044 тэрбум төгрөг болж тэнцэл (577) тэрбум төгрөгийн алдагдалтай гарав.</p>	<p>Өмнөх сараас 0.8 хувиар нэмэгдэж, оны эхнээс 5.1 хувь өсч өмнөх оны мөн үеэс 5 хувь өссөн байна.</p>	<p>Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх сараас 1.8 хувиар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 11.4 хувиар нэмэгдэж 1171 тэрбум төгрөгт хүрэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээл 8.8% байна.</p>	<p>Монголбанкны валютын нөөц 8-р сард өмнөх сараас 17.3 хувь буюу 236 сая ам.доллараар өсч 1599 сая ам.доллар болов.</p>

<p><b>\$</b> Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш <b>2443.53 ₮</b></p>	<p><b>1.009</b> Орон сууцны үнийн индекс Өмнөх сараас 0.6%-иар өсч, өмнөх оны мөн үеэс 0.6%-иар буурав.</p>	<p><b>12%</b> Монголбанкны бодлогын хүү</p>
--	---	---

Манай улсын хилээр 2017 оны эхний хагас жилд давхардсан тоогоор 2801 мянган зорчигч нэвтэрсэн нь өмнөх оны мөн үеэс 368.5 (15.2 хувь) мянгаар өсжээ. Улсын хилээр орсон зорчигчдын 37.6 хувь нь Замын-Үүд, 15.7 хувь нь Гашуун сухайт, 15.1 хувь нь Буянт-Ухаа, 11.8 хувь нь Алтанбулаг, 6.6 хувь нь Шивээ хүрэн, 13.2 хувь нь бусад боомтоор орсон байна. *Үндэсний статистикийн хороо*

**Экспортод гаргадаг гол түүхий эдийн үнэ, хэмжээ**

Манай улсын экспортын гол бүтээгдэхүүний сар тутмын экспортын хэмжээ болон дундаж үнийг графикаар, хүснэгтээр оны эцсийн байдлаар үзүүлээ.



Сүүлийн 3 жилийн хугацаанд МУ-ын экспортын түүхий эд, өссөн дүнгээр (тэрбум ам.доллар, сая тонн)

Голлох бүтээгдэхүүн	2015 он		2016 он		2017 оны 8-р сар	
	Хэмжээ	Орлого	Хэмжээ	Орлого	Хэмжээ	Орлого
Чулуун нүүрс	14.4	0.6	25.7	9.7	23.2	1.5
Төмрийн хүдэр	6.3	0.2	6.1	2.4	3.8	2.0
Зэсийн баяжмал	1.4	2.3	1.5	1.6	9.0	10.3
<b>Нийт</b>	<b>22</b>	<b>3</b>	<b>33</b>	<b>14</b>	<b>36</b>	<b>14</b>

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл долдугаар сарын эцэст 1.1 их наяд төгрөг болов.


**ДНБ**

ДНБ 2017 оны 2-р улирлын байдлаар (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 4.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 398.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж эдийн засаг 5.6 хувиар өсөв. ДНБ 5.6 хувиар өсөхөд бүтээгдэхүүний цэвэр татвар 24 хувь, үйлчилгээний салбар 9 хувиар өссөн нь нөлөөлөв.



**Төсөв**

Улсын нэгдсэн төсвийн орлого өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 25.4 хувиар өсч, зарлага 6.1 хувиар буурч төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 577 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Татварын нийт орлого 3.9 их наяд төгрөг болоход орлогын албан татвар 52.4 хувь, нэмэгдсэн өртгийн албан татвар 45 хувь, гадаад үйл ажиллагааны орлого 67 хувь, нийгмийн даатгалын орлого 67 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.




**Валютын ханш**

Наймдугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 254.4 төгрөг буюу 11.6 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 34 төгрөг буюу 1.4 хувиар нэмэгдэж 2443.53 төгрөгт хүрэв.



**Инфляци**

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2017 оны 8-р сард өмнөх сараас 0.8 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 5.1 хувиар өсч, өмнөх оны эцсээс 5 хувиар өсөв. Инфляци 5 хувиар өсөхөд энэ сард тээврийн хэрэгслийн худалдан авалт, хүнсний бараа ялангуяа (хүнсний ногоо, согууруулах бус ундаа) боловсролын үйлчилгээний үнийн дүн өсөхөд нөлөөлсөн байна.



\* Урьдчилсан гүйцэтгэл; Эх сурвалж ҮСХ, Монголбанк

**Гадаад валютын нөөц**


Гадаад валютын улсын албан нөөц 2017 оны 8-р сарын байдлаар 1599 сая ам.доллар болж өсөв. Энэ нь өмнөх сараас 17.3 хувь буюу 236 сая ам.доллараар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 40 хувь буюу 457 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм.



\* Эх сурвалж Монголбанк

**MSE-20 индекс**


2017 оны 8-р сард 1 их наяд төгрөгийн гүйлгээ хийж, 58.3 сая ширхэг үнэт цаас арилжсан нь өмнөх оны мөн үеэс гүйлгээ 879.8 (6.5 дахин) тэрбум төгрөгөөр өсжээ. ТОП-20 дундаж индекс 8-р сард 14790.8 нэгж болж, өмнөх оны мөн үеэс 2332.1 нэгжээр, өмнөх сараас 1180.6 нэгжээр тус тус өсчээ.



\* Монголын хөрөнгийн бирж


**Мөнгө**

Мөнгөний нийлүүлэлт (M2) өмнөх оны мөн үеэс 28 хувиар нэмэгдэж, өнгөрсөн сараас 3.7 хувиар өсч 14.5 их наяд төгрөгт хүрэв. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө өнгөрсөн оныхоос 8.8 хувиар, өмнөх сараас 0.2 хувиар буурч нийт мөнгөний 6.1 хувийг эзэлж байна.



**Хадгаламж**

Нийт хадгаламж 2017 оны 8-р сард 9.8 их наяд төгрөг болж өмнөх сараас 113.3 тэрбум төгрөг буюу 1.2 хувиар өсөв. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 22 хувиар буюу 1780.5 тэрбум төгрөгөөр өсөв. Өмнөх сараас валютын хадгаламж 4.6 хувиар буюу 211.2 тэрбум төгрөгөөр, төгрөгийн хадгаламж 1.6 хувиар буюу 231 тэрбум төгрөгөөр буурсан байна.



**Зээл**

ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2017 оны 8-р сард өмнөх сараас 1.7 хувиар нэмэгдэж, өнгөрсөн оны мөн үеэс 6.7 хувиар нэмэгдэж 13.2 их наяд төгрөг болов. Чанаргүй зээлийн хэмжээ 1171 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 1.8 хувиар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 11.4 хувиар нэмэгдэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 8.8% байна.



**Ипотекийн зээл**


2017 оны 8-р сарын байдлаар нийт ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 0.2 хувь (10.1 тэрбум төгрөг), өмнөх оны мөн үеэс 7.8 хувь (302.7 тэрбум төгрөг)-өөр нэмэгдэж нийт 4.1 их наяд төгрөгт хүрэв. Наймдугаар сард нийт 209 зээлдэгчид 10.1 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгож, нийт зээлдэгчдийн тоо 92347-д хүрэв. 2017 оны наймдугаар сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдлийн 99.5 хувь нь төгрөгийн зээл, 0.5 хувь нь валютын зээл байна.



## Гадаад худалдаа

Гадаад  
худалдаа

2017 оны наймдугаар сарын байдлаар нийт барааны эргэлт 6856 сая ам.доллар, үүнээс экспорт 4102 сая ам.доллар, импорт 2754 сая ам.долларт хүрч гадаад худалдааны тэнцэл 1348 сая ам.долларын ашигтай гарлаа. Экспорт 8-р сард өмнөх оны мөн үеэс 1.1 тэрбум ам.доллараар өсч, нүүрсний экспорт 1.2 тэрбум ам.доллараар өссөн нь голлон нөлөөлсөн байна.



\* Эх сурвалж УСХ, Монголбанк

Гадаадын  
шууд  
хөрөнгө  
оруулалт

Гадаадын шууд хөрөнгө оруулалт 2017 оны 8-р сард -123.8 сая ам.долларын сөрөг үр дүнтэй гарлаа. Харин өмнөх оны мөн үеэс 135.5 сая ам.доллараар буурсан үзүүлэлт юм. Өмнөх сартай харьцуулахад Монгол Улсаас гадаад руу гаргасан хөрөнгө оруулалт -0.2 сая ам.доллар байсан бол Монгол Улсад 148.4 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгджээ.



\* Эх сурвалж Монголбанк


## Монгол Улсын гадаад өр

### Гадаад өр

2017 оны хоёрдугаар улиралд Засгийн газрын нийт гадаад өр 6 тэрбум ам.доллар, Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 25 тэрбум ам.доллар болсон байна. Энэ нь өмнөх улирлаас ЗГ-ын өр 3 хувь (171 сая ам.доллар), Улсын нийт гадаад өр 1 хувь (257 сая ам.доллар)-иар тус тус өссөн байна. Тайлант улиралд нийт Улсын гадаад өрийн 24 хувийг засгийн газрын өр, 7 хувийг Төв банкны өр, 9 хувийг хадгаламжийн байгууллагуудын өр, 31 хувийг бусад салбаруудын өр, 28 хувийг компани хоорондын зээллэгийн өр тус тус эзэлж байна.



### МУ-ЫН НИЙТ ГАДААД ӨРИЙН БҮТЭЦ ХУВИАР



Эх сурвалж Монголбанк

### Сарын онцлох үйл явдал

#### 8.05

ОУВС-гийн ажлын хэсгийнхэн Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал, явцад урьдчилсан үнэлгээ өгөхөөр ажиллав. Эдийн засаг сэргэж байна. Нүүрс олборлолт, экспорт эрчимтэй нэмэгдэж, хувийн хөрөнгө оруулалт их хэмжээгээр өсөж, ОУВС тэргүүтэй хөгжлийн түншүүдийн 5.5 тэрбум ам.долларын санхүүжилт батлагдсаны дараа эдийн засагт итгэх итгэл сэргэсний ачаар ДНБ энэ онд хоёр хувийн өсөлттэй гарах талаар дүгнэлт хэлэв. Энэ оны эхний 6 сарын гадаад худалдаа 2015 болон 2016 оны эхний 6 сарын дүнтэй харьцуулахад экспорт өсөв. 2017 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр экспорт өнгөрсөн оны мөн үеэс 41 хувиар буюу 912 сая ам.доллараар өссөн байна. Уул уурхайн түүхий эдийн экспортын өсөлт нийт экспортыг 38.7 нэгж хувиар, уул уурхайгаас бусад төрлийн экспорт нийт экспортыг 2.9 нэгж хувиар өсөхөд нөлөөлсөн. Чулуун нүүрс олборлолтын хувьд өнгөрсөн онд 9.6 сая тонныг экспортод гаргасан бол энэ оны эхний 6 сард 18.9 сая тонныг худалдаалаад байна. Ирэх есдүгээр сард Монгол банкны данс руу дахин 37.8 сая ам.долларыг тус сангаас шилжүүлнэ. Энэ эх үүсвэрийг төсвийн алдагдлыг бууруулахад биш, ам.долларын ханшийг бууруулахад зарцуулна.